

**Аймгийн удирдах ажилтнуудын 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн  
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг, даалгавар**

2023.11.10

Чойр

№	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Биелэлт
1	<p align="center">Байгууллагууд Говьсүмбэр аймагт харьяалалгүй албан хаагчдынхаа судалгааг гарган НБХэлтсийн <a href="mailto:enkhbaatarhulan529@gmail.com">enkhbaatarhulan529@gmail.com</a> хаягт ирүүлэх</p>	2023.11.03	<p>2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар Говьсүмбэр аймагт харьяалалгүй албан хаагчийн судалгааг 15 байгууллага ирүүлсэн бөгөөд 85 албан хаагч харьяалалгүй байна.</p> <p>Судалгаа ирүүлээгүй байгууллага-23 Шивээговь сумын ЗДТГ Баянтал сумын ЗДТГ Татварын хэлтэс Статистикийн хэлтэс Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба Соёл урлагийн газар Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар Нийгмийн даатгалын хэлтэс Эрүүл мэндийн даатгалын хэлтэс Биеийн тамир, спортын газар Политехник коллеж Шүүхийн шинжилгээний хэлтэс Улсын бүртгэлийн хэлтэс Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар Ус цаг уур, орчны шинжилгээний газар Сум дундын ойн анги ОНӨҮГазар Ус Ду ОНӨААТҮГазар Талын Илч ОНӨҮГазар Илчлэг Шивээ ОНӨҮГазар Цөм сүрэг ОНӨҮГазар Говьсүмбэр аймаг дахь Авто тээврийн төв Нийтийн номын сан Боржигин өв музей</p> <p align="right"><b>Үүргийн биелэлт 50 хувь</b></p>
2	<p align="center">АИТХ-ын ээлжит бус хуралдаанд мэдээлэл танилцуулах байгууллагын удирдлагууд болон харьяа хэлтсийн дарга нар өөрийн биеэр оролцох</p>	2023.11.01	<p>Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдаанд АЗДТГ-ын хэлтсийн дарга нар, Баянтал сумын Засаг дарга, ХХҮГ, ХХААГ, МЭГ, БШУГ, ЭМГ, УС-ДУ ОНӨААТҮГ, Талын илч ОНӨААТҮГ, Илчлэг Шивээ ОНӨААТҮГ, БЗӨБЦТС ТӨХК-ийн захирал, удирдах албан тушаалтнууд бүгд оролцсон.</p> <p align="right"><b>Үүргийн биелэлт 100 хувь</b></p>

3	Өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх явцын мэдээллийг танилцуулах	2023.11.13	<p>Аймгийн Засаг даргын 2023 оны А/216 дугаар захирамжаар 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилт 88.6 хувьтай. Үүнд хүнс хөдөө аж ахуй салбар 80.6 хувь, төв суурин газрын бэлтгэл 96.6 хувийн гүйцэтгэлтэй.</p> <p><b><u>Хүнс хөдөө аж ахуйн салбар:</u></b></p> <p>Аймгийн аюулгүйн нөөцөд 30 тонн тэжээл, өвсний нөөц бүрдүүлэх 80 сая төгрөгийн 7000 ширхэг буюу 140 тн өвс авах тэндер зарлаж Далай дартан ХХК шалгарч 2970 боодол өвсийг хүлээж аваад байна.</p> <p>Сүмбэр сумын аюулгүйн нөөцөд 50 тонн өвс, 25 тонн, тэжээл, Шивээговь сум аюулгүйн нөөцөд 25 тонн өвс худалдан авахаар гэрээ байгуулсан.Баянтал сумын аюулгүйн нөөцөд 15 тонн өвс бэлтгээд байна.</p> <p>Өвс тэжээлийн нөөц малчин өрхийн хэмжээнд 6671 тн өвс, 977 тн үйлдвэрийн тэжээл, 101 тн гар тэжээл, 550 тн хужир, шүү бэлтгэсэнээр өвөлжилтийн бэлтгэл ажлыг 96,6 хувийн гүйцэтгэлтэй хангасан байна. Аймгийн хэмжээнд хадлангийн 6 салаа, 2 иргэн Хэнтий, Төв аймаг, Баянтал сумын Их бага уулын ойролцоо хадланд гарч нийт 616 тн өвс хадан орон нутгийн малчдад 275 тн өвсийг худалдан борлуулж, 2 салаа, 2 иргэн өөрсдийн хэрэгцээнд 220 тн өвсийг хадан авсан.</p> <p>Нийт бог малд үзлэг ангилалт хийхэд дундаас дээш тарга хүчтэй мал 65 хувьтай ба нийт малын 27.9 хувь буюу 176874 толгой малыг эдийн засгийн эргэлтэд оруулахаар тооцсоноос 1080 толгой малын эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. Ужиг халдварт 8 нэр төрлийн вакцинжуулалтанд 71.3 мян.тол мал хамруулж 85 хувьтай, Гоц халдварт 3 нэр төрлийн дархлаажуулалтанд 607.1 мян.тол мал хамруулж 96.5 хувьтай, зоонозын халдварт, бруцеллёзоос урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд 91.1 мян.тол төл мал хамруулж 98 хувьтай, Паразиттах өвчнөөс сэргийлэх 3 нэр төрлийн арга хэмжээнд 324.5 мян.тол мал, амьтан хамруулж 56 хувьтай хийгдсэн. Мал эмнэлэг ариун цэврийн ариутгал халдваргүйтгэлд МАА-н гаралтай 80400м2 талбай хамруулж 92 хувьтай.</p> <p>Бэлчээрийн даацын судалгааны дагуу Малхын отрын бүсэд Говьсүмбэр аймгаас 75.2 мян.тол мал, Төв аймгаас 14.0 мян.тол мал өвөлжүүлэхээр шийдвэрлэсэн. 2022 оны жилийн эцсээр 4 зоорийн нийт 134 тн мах нөөцөлсөн улирлын нөөцөд 20тн мах бэлтгэсэн. энэ оны мах нөөцлөх хугацаа болоогүй байна.</p> <p><b><u>Төв суурин газрын бэлтгэл:</u></b></p> <p>УС-ДУ ОНӨААТҮГ Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө 90.4%-тай хэрэгжиж байна. Энэ онд нийт 268,0 сая төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн. Шивээ овоо ХК-тай 9650тн нүүрс худалдан авахаар гэрээ байгуулсан. 2023 оны 1-9 сарын хугацаанд 6630 тн нүүрсийг аваад байна.</p> <p>ИЛЧЛЭГ-ШИВЭЭ ОНӨААТҮГГазар нь 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажил 91,8%-тай хэрэгжиж байна. Шивээ Овоо ХК-тай 6100 тн нүүрсний гэрээ байгуулж үүнээс 232 тн буюу 9.25 сая төгрөгийн нүүрсийг татаж авсан. 2023-2024 оны</p>
---	--	------------	--

			<p>Шатхууны хэрэглээний гэрээг НИК ХХК-тай 47,0 сая төгрөгөөр гэрээ байгуулж үүнээс 18 сая төгрөгийн шатхууныг хэрэглээд байна.</p> <p>“ТАЛЫН-ИЛЧ” ОНӨААТҮГазар нь 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл байдлын нүүрс худалдаж авах тендерийг зарлаад байна. өвөлжилтийн бэлтгэл ажил 100% хэрэгжсэн. Ховилын уурхайтай 2380 тн нүүрсний гэрээ байгуулсан. үүнээс 1500 тн нүүрсийг нь хэрэглээнд зарцуулсан</p> <p>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын нутаг дэвсгрийн авто замын давсыг “Тохижилт Сүмбэр” ОНӨААТҮГазар нь “ЭТСО” ХХК-тай 2023 оны 09 сарын 19-ний өдөр гэрээ байгууллан 8.4 сая төгрөгөөр 10.5 тн давс худалдан авч давсны нөөцийг бүрдүүлсэн.</p>
--	--	--	--

**Үүргийн биелэлт 88.6 хувь**

**Дундаж хэрэгжилт – 79.5 хувь**

**Хянасан:** ХШҮ-ний хэлтсийн дарга:

М.АНХБАЯР

**Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:**  
ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

Б.МӨНХЗАЯА

